



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ

**БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ**

**БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САРД
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

СӨҮЛ ХОТ

2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд Монгол Улс, БНСУ-ын Хөдөлмөрийн Яам хоорондын “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо”-ны дагуу БНСУ-д ажиллах хүч илгээх тухай харилцан ойлголцлын санамж бичиг, ХНХЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд ажил олгогч, ажилтан хоёрын хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээнд хяналт тавьж биелэлтийг хангуулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Монгол Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газар, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг, бусад холбогдох хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэн, БНСУ-д ажиллаж амьдарч буй иргэдийнхээ эрх ашгийг хамгаалан ажиллаж байна.

Төв нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг, Нийгмийн даатгалын тасаг гэсэн 2 тасагтайгаар тайлант хугацаанд ажлын чиг үүрэг, хуваарийн дагуу дараах ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААТАЙ ХОЛБООТОЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

- 1.1 Хөдөлмөрийн гэрээт ажилчидтай холбоотой өргөдөл, гомдлын хүрээнд
- 1.2 БНСУ-д хууль бусаар ажиллаж байгаа иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын хүрээнд
- 1.3 Гэрээт ажилчдын ахисан түвшний боловсролыг дэмжих ажлын хүрээнд

2. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, НИЙГМИЙН ДААТГАЛТАЙ ХОЛБООТОЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

- 2.1 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох
- 2.2 БНСУ-д оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах, нийгмийн хамгааллын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох
- 2.3 Нийгмийн даатгалын сангийн орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд
- 2.4 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр (Е-9, Н-2 визээр) ажиллах хугацаандаа тус улсын Үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн иргэдийн шимтгэлийг олгуулах ажлын хүрээнд

3. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН БУСАД АЖЛУУД

- 3.1 Мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд
- 3.2 Сургалт, судалгааны ажлын хүрээнд
- 3.3 Бусад дотоод ажлын хүрээнд

1. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААТАЙ ХОЛБООТОЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 01 дүгээр сарын 31-ний өдрийн хооронд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт 327 иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, Үндэсний тэтгэврийн алба болон ажил олгогч эзэд, холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрхзүйн зөвлөгөө өгөх зэргээр үйлчилгээ үзүүлэн, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллав.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын “Самсунг” даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, нутаг буцах зардал, гэнэтийн ослын даатгал, үйлдвэрлэлийн ослын даатгал, авч чадаагүй цалин хөлс зэрэг нийт 12,820,755 вон /арван хоёр сая найман зуун хорин мянга долоон зуун тавин тав/-ыг Монгол Улсын иргэдэд олгууллаа. Үүнд, хөдөлмөрийн гэрээт иргэдийн авч чадаагүй цалин хөлс 10,727,435 вон, хууль бусаар ажилладаг иргэдийн авч чадаагүй цалин хөлс 2,093,320 воныг ажил олгогчоос тус тус гаргуулан өргөдөл гаргагчдад олгуулсан.

1.1 Хөдөлмөрийн гэрээт ажилчидтай холбоотой өргөдөл, гомдлын хүрээнд:

- Төвийн цахим хуудсаар ирж буй өргөдлийг төрөлжүүлэн хүлээн авч, 71 иргэний санал, хүсэлтэд холбогдох зөвлөгөө мэдээллийг өгөв.
- Хөдөлмөрийн гэрээт ажилтан Ш.О-ын виз болон хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх асуудлаар Чонжу хотын ХМШГ, гадаадын иргэн харьяатын газруудад очин холбогдох материалуудыг өгч, орчуулга хийн ажиллав.
- Хөдөлмөрийн гэрээт ажилтан О.С, Б.Х нарын олгогдоогүй цалин, төлөгдөөгүй нийгмийн даатгалын шимтгэлийн асуудлаар 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр ХЭХЯ-ны Мугпу хотын салбарт ажиллав.
- Хөдөлмөрийн гэрээт ажилтан Ш.О-ын асуудлаар 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Чонжу хотын иммегрэйшн болон Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яамны салбарт ажиллав.
- Сэтгэл зүйн чиглэлээр 31 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч, танилцуулга видео /reels/ бэлтгэж нийтлэн, 2023 онд хөдөлмөрийн гэрээгээр ирсэн 524 иргэнд масс мессеж илгээв. Сэтгэл зүйн чиглэлээр ганцаарчилсан зөвлөгөө 1 иргэнд үзүүлж, 12 оюутныг бүлгийн сэтгэл засалд хамруулав. Сэтгэл гутралтай 2, сэтгэл түгшилттэй 1, ажлаас халшрах хам шинжтэй 2, архины асуудалтай 1, нойрны хямралтай 5 иргэнийг тус тус илрүүлэн зөвлөгөө, мэдээлэл өгөв.

1.2 БНСУ-д хууль бусаар ажиллаж байгаа иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын хүрээнд:

- Хууль бусаар хөдөлмөр эрхэлж буй А.А-д олгогдоогүй цалин 500,000 воныг ажил олгогчоос нэхэмжлэн олгуулав.
- Хууль бусаар хөдөлмөр эрхэлж буй Т.Д-д олгогдоогүй цалин 500,000 воныг ажил олгогчоос нэхэмжлэн олгуулав.
- Хууль бусаар хөдөлмөр эрхэлж буй Г.А-ын олгогдоогүй цалингийн асуудлаар 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр ХЭХЯ-ны Ансан хотын салбарт мэдүүлэг өгч,

хойшлогдсон цалингийн тодорхойлолтыг гаргуулан 4,500,000 воныг хөдөлмөр халамжийн корпорациас олгуулав.

- Хууль бусаар хөдөлмөр эрхэлж буй О.Ү-ийн олгогдоогүй цалингийн асуудлаар 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр ХЭХЯ-ны Ансан хотын ХМШГ-т мэдүүлэг өгч 4,950,000 воныг хөдөлмөр халамжийн корпорациас олгуулав.
- Хууль бусаар хөдөлмөр эрхэлж буй М-ын авч чадаагүй цалин 500,000 воныг олгуулав.

1.3 Ахисан түвшнийг дэмжих ажлын хүрээнд

- Е-9 статусаас Е-7-4 рүү визний ангиллаа солиулж ахисан түвшинд хүрэх хүсэлтэй иргэдийг бүртгэлийн санд оруулж, холбогдох сургалтад бүртгүүлэх, бусад зөвлөгөө мэдээлэл өгч, оноог тооцоолж өгөв.

1.4 Гадаад харилцаатай холбоотой ажлын хүрээнд

- Хөдөлмөрийн атташе, мэргэжилтэн Ж.Жаргалсайхан, Э.Энхбилэг нар БНСУ-ын Гёнгү аймгийн Ёжү хотын сургалтын төвийн хэлтсийн дарга Ким Жэ Хён, Монгол Улсын хөдөлмөрийн гэрээт иргэдийн сургалт хариуцсан ажилтан Рю Сон Хуан нартай албан уулзалт хийж, гэрээт иргэдийн ирэхийн дараах сургалтыг сэргээх талаар харилцан тохиролцов.
- БНСУ-ын Өмнөд Чолла муж дахь Монгол Улсын Өргөмжит Консулын хэлтэс, Монгол Улсаас БНСУ-д суугаа ЭСЯ-ны Консулын хэлтэс, Пусан хотод суугаа Консулын газар, БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв хамтран Гуанжу хотын Монголын соёлын төвд явуулын үйлчилгээг зохион байгуулж, Хөдөлмөрийн харилцаа, сэтгэл зүйтэй холбоотой асуудлаар 41 иргэнд, нийгмийн даатгалд шинээр хамрагдах, сайн дурын даатгалын асуудлаар 54 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав.
- БНСУ-ын АҮХНХЭГ-тай 2024 онд хамтран ажиллах график төлөвлөгөөг боловсруулан илгээв.
- БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөр, халамжийн газрын судалгааны хүрээлэнгийн хэлтсийн дарга Жу Хён Күтай 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр уулзалт зохион байгуулав.

2. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, НИЙГМИЙН ДААТГАЛТАЙ ХОЛБООТОЙ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД

2.1 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох ажлын хүрээнд

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд 18 иргэнийг шинээр хамруулан “Солонгос улсад гэрээгээр ажиллагсдын программ”-д мэдээллийг бүртгэн гэрээ

байгуулав. Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэдэд шинээр 17, гэрээний хугацаа сунгасан 24, ажлын байраа сольсон, гэрчилгээг гэж үрэгдүүлсэн, албан байгууллага нь хүсэлт гаргасан 9 даатгуулагчид Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг тус тус бичиж олгов.

2.2 БНСУ-д оршин сүүж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох

2024 оны 01 дүгээр сараас нийгмийн даатгалын системийн шинэчлэлтэй холбоотойгоор тус тасгийн сайн дурын даатгалын шимтгэлийг төгрөгөөр төвлөрүүлэх чиглэлийг НДЕГ-аас ирүүлсэн. Үүний дагуу холбогдох төгрөгийн дансыг 01 дүгээр сарын 08-ны өдөр Хаан банканд нээлгэсэн. Энэ тухай мэдээллийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар тус тасагт бүртгэлтэй 883 даатгуулагчид мэдэгдэх, өмнө нь воноор төлж байсан шимтгэлийг төгрөгт шилжүүлэн бодож даатгуулагч бүрд мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулан ажиллав.

Нийт 47 иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулав. БНСУ-ын ААН-д хөдөлмөр эрхэлдэг 58 даатгуулагчийн хүсэлтийн дагуу Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг бичиж олгов.

2.3 Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд

НДЕГ-ын даргын 2024 оны А/02 дугаар тушаалаар тус тасгийн 2024 оны орлогын төлөвлөгөө 4,997,799,000.00 төгрөгөөр батлагдсан бөгөөд сар бүрийн орлогын төлөвлөгөө 416,483,250.00 төгрөг болно.

Тус тасаг нь тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл 42,230,000.00 вон буюу 111,909,500.00 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн.

Солонгос улсад гэрээгээр ажиллагсдын программд гэрээний хугацаа, шимтгэл төлөлтийн тооцоог тус тус хянаж ажиллав.

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын ажил олгогчдод тухайн сарын болон өмнөх саруудын шимтгэл төлөхийг сануулж, 327 ширхэг нэхэмжлэл факсаар илгээн, нийт 1,029 даатгуулагчтай шимтгэл төлөхийг шаардаж утсаар холбогдов.

2.4 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр (Е-9, Н-2 оршин сүүх эрхээр) ажиллах хугацаандаа тус улсын Үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн иргэдийн шимтгэлийг буцаан олгуулах ажлын хүрээнд

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар ирүүлсэн 198, 199 дүгээр ээлжийн 4 иргэний материал НДЕГ-аас ирснийг БНСУ-ын ҮТА-д

хүргүүлж ажилласан. Өмнө нь НДЕГ-аас ирсэн 191 дүгээр ээлжийн 7 хүний хариу бүрэн шийдвэрлэгдэж, нийт 58,851,910 воны буцаан олголт иргэдийн дансанд шилжсэн байна.

3. ТӨВИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН БУСАД АЖЛУУД

3.1 Мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд

- Төвийн үйл ажиллагаа, мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр төвийн цахим хуудсанд 3 мэдээ, төвийн нийтийн цахим хуудсанд 14 мэдээ мэдээлэл оруулан ажиллав.
- Төвийн 2023 оны 12 сарын үйл ажиллагааны тайланг цахим хуудсанд оруулав.
- Төвийн 2023 оны 12 сарын тоон мэдээллийг цахим хуудсанд инфографикаар оруулав.
- Төвийн ДАУТОГ 2024 оны 1 сарын 17-ны өдөр MNB телевизийн “Ажил мэргэжил” хэлэлцүүлэгт яриа өгөв.
- БНСУ-ын хөдөлмөрийн яамны хөдөлмөрийн зах зээлийн судалгааны газрын 2023 оны ажиллах хүчний судалгааны дүнгээр 2 постер хийж нийтийн цахим хуудсанд оруулав.
- Цахим хуудсанд 13 дахь сарын цалингийн зөвлөгөө оруулав.
- Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 1,195, үүнээс 1,112 иргэн, даатгуулагч, ажил олгогчид утсаар, 83 иргэн, даатгуулагчид биечлэн Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар болон бусад төрлийн мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч, сурталчилгааны материал тараан ажиллав.
- Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн тухай, БНСУ дахь нийгмийн даатгалын үйлчилгээний шинэчлэлтийн тухай мэдээллийг иргэд, даатгуулагчдад өгөх зорилгоор төвийн “БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” фэйсбүүк хуудсаар 01 дүгээр сарын 03, 04, 08-ны өдрүүдэд 3 удаагийн мэдээлэл нийтэлсэн.
- 01 дүгээр сарын 12, 19, 26-ны өдрүүдэд МУ-аас хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар БНСУ-д ирэх гэрээт ажилчдад ирэхийн өмнөх сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулж, нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн тухай мэдээ, мэдээлэл өгөв.
- 01 дүгээр сарын 27-ны бямба гаригт тус төвөөс БНСУ-ын Өмнөд Чолла мужийн Гуанжу хотод ажиллаж, амьдарч буй Монгол иргэддээ “Нийгмийн даатгалын явуулын үйлчилгээ”-г үзүүлж ажилласан. Нийт 54 иргэнд нийгмийн даатгалын хууль тогтоомжийн тухай мэдээ, мэдээлэл хүргэж ажиллав.
- 01 дүгээр сарын 21, 28-ны өдөр тус төвийн “БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” фэйсбүүк хуудас, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны фэйсбүүк хуудсаар тус тус “Лайв” нэвтрүүлэг хийж, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн тухай, БНСУ-д үзүүлж буй нийгмийн даатгалын үйлчилгээний талаар мэдээлэл өгч, иргэд, даатгуулагчдаас ирсэн асуултад хариулав.

3.2 Сургалт, судалгааны ажлын хүрээнд

- БНСУ-д 2024 оны 01 дүгээр сард хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 133 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг цахим хэлбэрээр 2024 оны 01 дүгээр сарын 12, 19, 26-ны өдрүүдэд зохион байгуулав. Иргэдэд:
 - ХНХҮТ-ийн үйл ажиллагааны товч танилцуулга
 - Солонгос улсын хууль, дүрэм, журам
 - Монгол иргэдийн гэмт хэрэгт холбогдож буй байдал
 - Үйлдвэрийн осол, үйлдвэрийн ослын даатгал, ХАБЭ, ослоос урьдчилан сэргийлэх
 - Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
 - Ур чадвартай ажиллах хүч E7 визний талаар
 - Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу талуудын талаар
- ХХҮЕГ-т БНСУ-д оршин сууж буй МУ-ын иргэдийн судалгаа, тоон мэдээллүүдийг боловсруулан хүргүүлэв.

3.3 Бусад дотоод ажлын хүрээнд

- ХУРДАН төрийн цахим үйлчилгээний системийн операторын горимоор 2 иргэнд үйлчилгээ, лавлагааг хүргэж ажиллав.
- ХНХҮТ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан ХНХЯ-нд хүргүүлэв.
- ХНХТ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт тавин баталгаажуулав.
- Архивын материалуудыг холбогдох журмын дагуу бүрдүүлэн хүлээлгэн өгөв.
- Байгууллагын гадна хаягийн эх бэлтгэлийг бэлтгэн хэвлүүлж, шинэчлэн байршуулав.
- ХНХ-ын сайдын 2023 оны А/197 тоот тушаал, НДЕГ-ын даргын 2023 №2 тоот удирдамжийн дагуу БНСУ дахь ХНХҮТ-ийн Нийгмийн даатгалын тасгийн шилэн дансны хуулийн хэрэгжилт, шилэн дансны цахим хуудасны 2023 оны хөтлөлт, өмнөх оны Үндэсний аудитын газрын зөвлөмж, албан шаардлага, үүрэг даалгаврын биелэлт, тайлагналтад дотоод хяналт хэрэгжүүлж тайланг цахимаар НДЕГ-ын Дотоод аудит мониторингийн газарт илгээв.
- Монгол Улсын Үндэсний аудитын газраас тус төвийн 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдал, санхүүгийн цэвэр үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд хийсэн завсрын аудитаас өгсөн зөвлөмж, актын биелэлтийг боловсруулан хүргүүлэв.
- 2024 оны мэргэжилтнүүдийн болон тасгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулав.
- Тасгийн үйл ажиллагаатай холбоотойгоор ХНХЯ-ны сайдад 1, НДЕГ-т 3, НДҮЗ-д 1, Хаан банкинд 2 нийт 7 албан бичиг хүргүүлэв.
- 2024 оны 01 дүгээр сараас нийгмийн даатгалын системийн шинэчлэлтэй холбоотойгоор тус тасгийн сайн дурын даатгалын шимтгэлийг төгрөгөөр төвлөрүүлэх болсонтой холбогдуулан Хаан банкинд шимтгэл төвлөрүүлэх дансыг нээлгэж, 01 дүгээр сарын 08-ны өдрөөс хэрэглээнд нэвтрүүлэв. Төгрөгийн дансыг хэрэглээнд нэвтрүүлсэн учраас өмнө нь сайн дурын даатгалын шимтгэл төвлөрүүлдэг байсан БНСУ-ын “Күкмин” банкны холбогдох виртуал дансыг хаах, 01

дүгээр сард шимтгэлээ шилжүүлсэн даатгуулагчдын шимтгэлийг буцаан олгох ажлыг зохион байгуулав. Нийт 56 даатгуулагчийн өргөдлийн дагуу даатгуулагчдын дансанд 01 дүгээр сарын воноор төлсөн шимтгэлийг буцаан шилжүүлсэн.

- Сайн дурын даатгалын шимтгэлийг төгрөгөөр шилжүүлэх арга хэмжээний хүрээнд тус тасагт бүртгэлтэй шимтгэл төлж буй 883 даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тооцооллын жагсаалтыг нэгтгэн боловсруулж, НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газарт илгээсэн.
 - Нийгмийн даатгалын аппликейшнд бүртгүүлэх 10 иргэний хүсэлтийг хүлээн авч, бүртгэлийг баталгаажуулан, иргэдэд бүртгүүлэх кодыг илгээв.
 - Нийгмийн даатгалын лавлагаа авах хүсэлт гаргасан 41 иргэний хүсэлтийг хүлээн авч, иргэдэд мэдээллийг өгсөн.
 - Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол нөхцөлийг хангасан, нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авах эрх үүссэн 3 даатгуулагчид зохих журмын дагуу даатгуулагчийн тодорхойлолтыг гаргаж, шаардлагатай бичиг баримтыг монгол хэл рүү хөрвүүлж өгөв.
 - Нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн 01 дүгээр сарын шимтгэлийн орлогыг НДЕГ-ын Төрийн сан дахь холбогдох дансанд шилжүүлэн, тайлан мэдээг гарган НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газрын холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.
 - 2023 оны 12 дугаар сар, 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан мэдээг 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тус тус нэгтгэн боловсруулж, НДЕГ, ХНХЯ-д хүргүүлэв. Мөн тасгийн 2021-2023 оны үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд хүргүүлсэн.
 - 2021-2023 оны тасгийн гүйцэтгэлийн болон дэлгэрэнгүй тайлан, 2023 оны мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, үнэлгээний хуудсыг НДЕГ-ын Дотоод аудит, мониторингийн газарт хүргүүлсэн.
 - 01 дүгээр сарын 30-ны өдөр гадаад хамтын ажиллагааны ажлын хүрээнд БНСУ-ын Эмэгтэйчүүдийн яамны харьяа Нийгэм, хамгааллын агентлагийн Сунбук дүүрэг дахь "Гэр бүлийн төв"-ийн хөтөлбөр арга хэмжээтэй холбогдох мэргэжилтнүүд танилцаж, санал солилцсон.
 - НДЕГ-аас зохион байгуулдаг "Цахим мэдээллийн цаг"-ийн 01 дүгээр сарын 12-ны өдрийн "Хүн амын орлогын албан татварын тухай хууль, тайлан гаргахад анхаарах асуудал" сэдэвт сургалт, 19-ны өдөр Авлигатай тэмцэх газраас нийгмийн даатгалын салбарын албан хаагчдад "ХАСХОМ мэдүүлэх нь" сэдэвт сургалтуудад мэргэжилтнүүд хамрагдав.
-
- **Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасгийн сар тутмын тоон мэдээ**

- /2024 оны 01 дүгээр сар/

№	Агуулга	Дүн
1	Иргэдэд олгуулсан мөнгөн дүн	12,820,755
2	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол	327